

“МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтад “Улсын Их Хурал нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтад “нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах” гэж тус тус заасны дагуу “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тайлант онд улсын төсвийн нийт орлого ба тусламжийг 16,226.2 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 17,177.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 105.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан.

Төсвийн тогтворжуулалтын санд 501.6 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр ААНОАТ-ын орлогоос 92.2 тэрбум төгрөг, АМНАТ-ийн орлогоос 583.7 тэрбум төгрөг, нийт 675.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн.

Монгол Улсын 2023 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 16,085.2 тэрбум төгрөгт хүрч, 105.9 хувийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөгөөнөөс 900.6 тэрбум төгрөгөөр давсан, мөн өмнөх оны гүйцэтгэлээс 5,850.0 тэрбум төгрөгөөр буюу 57.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн нийт орлого ба тусламжийн дүн /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022 он	2023 он			
	Гүйц	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Нийт орлого ба тусламжийн дүн	11,629.7	16,226.2	17,177.3	105.9	951.1
Тогтворжуулалтын сан	1,394.6	501.6	675.9	134.7	174.3
Ирээдүйн өв сан	-	540.0	416.2	77.1	(123.8)
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	10,235.1	15,184.6	16,085.2	105.9	900.6
Татварын орлого	8,917.8	12,459.0	13,715.0	110.1	1,256.0
Татварын бус орлого	1,317.3	2,725.6	2,370.2	87.0	(355.5)

Монгол Улсын 2023 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 16,079.8 тэрбум төгрөг буюу 94.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Нийт зарлага ба цэвэр зээлийн 74.4 хувийг урсгал зардал, 24.6 хувийг хөрөнгийн зардал, 1.0 хувийг эргэн төлөгдөх цэвэр зээл эзэлж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022 он	2023 он			
	Гүйц	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	11,359.9	16,949.9	16,079.8	94.87	870.15
Урсгал зардал	8,483.4	12,574.1	11,960.6	95.12	613.49
Бараа, ажил үйлчилгээний зардал	2,688.8	3,821.1	3,614.5	94.59	206.65
Хүү	808.0	1,093.5	1,092.6	99.92	0.88
Татаас ба урсгал шилжүүлэг	4,986.5	7,659.5	7,253.5	94.70	405.96
Хөрөнгийн зардал	2,764.2	4,381.4	3,951.9	90.20	429.50
Эргэж төлөгдөх цэвэр зээл	112.4	(5.6)	167.3	(2,993.67)	(172.84)

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.1, 8.10.2 дахь заалтад тус тус заасны дагуу нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийлгэн улсын төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагын хэмжээг баталгаажуулсан болно.

---o0o---

“МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтад “Улсын Их Хурал нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтад “нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах” гэж тус тус заасны дагуу “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн нийт орлого 24,387.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 22,509.0 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 785.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан нь дотоодын нийт бүтээгдэхүүн¹-ий 1.1 хувьтай тэнцэж байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 785.9 тэрбум төгрөгийн ашигтай гарч, төлөвлөсөн дүнгээс 3.0 их наяд төгрөгөөр эерэг үзүүлэлттэй байна.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудад дараах байдлаар нийцэж байгаа болно:

1.Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх:

Монгол Улсын 2023 оны төсвийн орлогын төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан уг тусгай шаардлагын дагуу боловсруулан батлуулж, төсвийн жилийн турш хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан ажиллалаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т заасны дагуу гол нэр төрлийн эрдэс баялгийн 2023 онд баримтлах тэнцвэржүүлсэн үнийг Олон улсын валютын сан болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн төсөөлөл хийдэг олон улсын нэр хүнд бүхий, Засгийн газраас тодорхойлсон санхүүгийн мэдээллийн байгууллагаас гаргасан өмнөх 20 жилийн дундаж үнэ болон тухайн төсвийн жил, түүний дараах 3 жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцсон. Эрдэс баялгийн үнийн төсөөллийг мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан зарчмын дагуу 2023 онд нэг тонн зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 8,386.7 ам.доллар, нүүрсний үнийг 110.8 ам.доллар байхаар тооцож, Төсвийн тогтворжуулалтын санд 501.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн.

Сүүлийн жилүүдэд Засгийн газар хилийн боомтын нэвтрэх хүчин чадлыг сайжруулах, экспортыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажилласны үр дүнд нүүрсний экспортын хэмжээг төлөвлөсөн хэмжээнээс 19.6 сая тонноор нэмэгдүүлж, 69.6 сая

¹ ДНБ-ний гүйцэтгэл, оны үнээр – 68,871,741.6 сая төгрөг
Эх сурвалж Үндэсний статистикийн хороо

тоннд хүргэсэн нь Төсвийн тогтворжуулалтын сан төлөвлөсөн хэмжээнээс 174.3 тэрбум төгрөгөөр илүү буюу 675.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхэд гол нөлөөг үзүүлээ.

2.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх:

Улсын Их Хурлаас төсвийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тухайлбал, хуулийн 19 дүгээр зүйлд “19.9.Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 12.5 хувиас, 2021 онд 8.8 хувиас, 2022 онд 5.1 хувиас, 2023 онд 3.6 хувиас, 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна.” гэсэн хэсэг нэмсэн.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2023 он
1 Хуулиар тогтоосон хязгаар	-3.6%
2 Гүйцэтгэл	1.1%

2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 785.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.1 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тэнцлийн тусгай шаардлагыг хангаж байна;

3. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т “тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх” гэж заасан.

Зарлагын өсөлтийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2023 он
1 Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь	23.2%
2 Тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь	23.3%
3 Тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж	15.3%

Нэгдсэн төсвийн нийт зарлага 2023 онд 23.2 хувиар өсөхөөр төсөөлөн батлагдсан нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төсвийн зарлагын өсөлтийн тусгай шаардлагыг хангаж байна;

4.Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 65 хувиас хэтрэхгүй байх:

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т “Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2023 оны төсвийн жилд 65 хувиас хэтрүүлэхгүй байна” гэж заасан. Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2023 оны эцэст 30.8 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 26.6 их наяд төгрөг буюу ДНБ-ий 38.6 хувьтай тэнцүү байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн талаар тусгай шаардлагыг бүрэн хангаж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн орлого, зарлагын талаар:

Монгол Улсын 2023 оны төсвийн нийт орлого ба тусламжийг 16,226.2 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 17,177.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 105.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан.

Төсвийн тогтворжуулалтын санд 501.6 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр ААНОАТ-ын орлогоос 92.2 тэрбум төгрөг, АМНАТ-ийн орлогоос 583.7 тэрбум төгрөг, нийт 675.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн.

Монгол Улсын 2023 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 16,085.2 тэрбум төгрөгт хүрч, 105.9 хувийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөгөөнөөс 900.6 тэрбум төгрөгөөр давсан, мөн өмнөх оны гүйцэтгэлээс 5,850.0 тэрбум төгрөгөөр буюу 57.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн нийт орлого ба тусламжийн дүн /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022 он	2023 он			
	Гүйц	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Нийт орлого ба тусламжийн дүн	11,629.7	16,226.2	17,177.3	105.9	951.1
Тогтворжуулалтын сан	1,394.6	501.6	675.9	134.7	174.3
Ирээдүйн өв сан	-	540.0	416.2	77.1	(123.8)
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	10,235.1	15,184.6	16,085.2	105.9	900.6
Татварын орлого	8,917.8	12,459.0	13,715.0	110.1	1,256.0
Татварын бус орлого	1,317.3	2,725.6	2,370.2	87.0	(355.5)

“Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хүрээнд экспортод гаргах нүүрсийг нээлттэй, цахим арилжаагаар хийж, хилийн үнээр борлуулж, боомтуудын нэвтрүүлэх чадварыг сайжруулснаар 2022 онд 0.7 тэрбум ам.долларын алдагдалтай байсан төлбөрийн тэнцэл 2023 онд 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Төлбөрийн тэнцэл ашигтай гарснаар гадаад валютын нөөц оны эцэст 4.9 тэрбум ам.долларт хүрч өмнөх оноос 44.7 хувиар өссөн байна.

Тайлант онд нүүрсний экспорт 69.6 сая тонн буюу төлөвлөгөөнөөс 19.6 сая тонноор, эдийн засгийн бодит өсөлт 7 хувь буюу төлөвлөгөөнөөс 1 пунктээр, нэрлэсэн ДНБ 68.9 их наяд төгрөг буюу төлөвлөгөөнөөс 14.4 хувиар тус тус давж биелсэн нь төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд гол нөлөөг үзүүллээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 16,079.8 тэрбум төгрөг буюу 94.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Улсын төсвийн нийт тэнцэл 5.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан.

Монгол Улсын 2023 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2022 он	2023 он			
	Гүйц	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	11,359.9	16,949.9	16,079.8	94.87	870.15
Урсгал зардал	8,483.4	12,574.1	11,960.6	95.12	613.49
Бараа, ажил үйлчилгээний зардал	2,688.8	3,821.1	3,614.5	94.59	206.65
Хүү	808.0	1,093.5	1,092.6	99.92	0.88
Татаас ба урсгал шилжүүлэг	4,986.5	7,659.5	7,253.5	94.70	405.96
Хөрөнгийн зардал	2,764.2	4,381.4	3,951.9	90.20	429.50
Эргэж төлөгдөх цэвэр зээл	112.4	(5.6)	167.3	(2,993.67)	(172.84)

Нийт зарлага ба цэвэр зээлийн 74.4 хувийг урсгал зардал, 24.6 хувийг хөрөнгийн зардал, 1.0 хувийг эргэн төлөгдөх цэвэр зээл эзэлж байна.

Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн зөрүүг арилгах зорилгоор даатгуулагчийн тэтгэвэр тогтооход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг өнөөгийн цалин хөлсний түвшинтэй жишиж ойртуулах итгэлцүүрийг Засгийн газрын 2014 оны 15 дугаар тогтоолоор суурь оныг 2011 он байсныг 2023 онд суурь оныг 2022 он болгож шинэчлэн итгэлцүүрийг тогтоосон.

Итгэлцүүр ашиглан тэтгэврийн зөрүүг арилгасны дараах сууриас тооцож тэтгэврийг 10 хувиар нэмэгдүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг шийдвэрлэснээр тэтгэвэр авагч ахмадуудын орлогын баталгаа сайжирч, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс үүдэлтэй эрсдэлийг бууруулав.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хот хөдөөгийн сэргэлт, хэт төвлөрлийг сааруулах зорилгоор орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар тооцож олгох, орон нутгийн удирдлага нь төрийн албан хаагчийнхаа цалинг 80 хүртэл хувиар нэмэгдүүлэн олгох эрх зүйн орчныг бий болгосноор тайлант онд 35.1 тэрбум төгрөгийн цалингийн нэмэгдэл олгосон.

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зохистой удирдаж, зарцуулсантай холбогдуулан гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагаас бусад байгууллагын 23,602 албан хаагчдад 25.7 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон үйл ажиллагаа, зардалд тавих хяналтыг сайжруулан, санхүүгийн сахилга батыг мөрдүүлснээр 2023 оны төсвийн жилд 122.8 тэрбум төгрөгийн хэмнэлт үүсгэж, өмнөх оноос 39.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар:

Монгол Улсын 2023 оны төсвийн хөрөнгөөр 2023 онд нийт 1143 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,965.6 тэрбум төгрөг батлагдсан. Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтын 1139 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2,686.0 тэрбум төгрөг, “Барих-шилжүүлэх” нөхцөлтэй концессын гэрээ байгуулсан 4 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд 279.6 тэрбум төгрөг тус тус батлагдсан.

Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх дээрх 1143 төсөл, арга хэмжээний 10 төсөл, арга хэмжээ нь шинээр, 1129 төсөл, арга хэмжээ нь он дамжин шилжин хэрэгжсэн бөгөөд санхүүжилтийн гүйцэтгэл 2,529.3 тэрбум төгрөг, концессын эргэн төлөлтөөр 4 төсөл, арга хэмжээнд 251.6 тэрбум төгрөг, нийт 2,780.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, 93.8 хувийн биелэлттэй байна.

Засгийн газраас төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг сайжруулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн батлагдсан төсвийн багцынхаа дүнд багтаан зохицуулалт хийх, барьцаа хөрөнгийн дансанд байршуулан гүйцэтгэлээр санхүүжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр төсвийн хөрөнгө оруулалтын бодит гүйцэтгэл сайжирсан байна. Мөн эдгээр төслүүдийг хэрэгжүүлсэн 1460 гаруй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж, 40.9 мянган ажлын байрыг хадгалж, 2,780.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр эдийн засгийг дэмжсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.1, 8.10.2 дахь заалтад тус тус заасны дагуу нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийлгэн улсын төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагын хэмжээг баталгаажуулсан болно.

---oOo---